



ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/06

Улаанбаатар хот
2012 он



ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуйн салбар	2
2. Газар тариалангийн салбар	3
3. Аж үйлдвэрийн салбар	5
4. Цаг агаар	10



1. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 13.5 сая хээлтэгч буюу 86.2 хувь нь 2012 оны эхний хагас жилд төллөсөн байна. Эм хонины 90.4 хувь, эм ямааны 86.6 хувь, үнээний 69.2 хувь, гүүний 65.6 хувь, ингэний 46.5 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.4 хувь буюу 13327.3 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 790.6 мянга буюу 6.3 хувиар их байна.

Унага бойжилт 97.6 хувь, тугал 98.1 хувь, ботго 98.1 хувь, хурга 98.7 хувь, ишиг 98.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.3-1.4 пунктээр өсчээ.

Зүй бусаар 2012 оны эхний эхний хагас жилд улсын хэмжээгээр 275.6 мян.толгой мал хорогдож, өмнөх оны мөн үеийнхээс 230.5 мян.толгой буюу 45.6 хувиар буурав. Зүй бусаар хорогдсон малыг төрлөөр авч үзвэл адуу 14.2 мянга, үхэр 25.6 мянга, тэмээ 608, хонь 111.1 мянга, ямаа 124.1 мянга байна. Нийт хорогдлын 40.3 хувийг хонь, 45.0 хувийг ямаа эзэлж байна.

Мал төллөлт

(жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}
Бүгд	10205.4	12862.6	13524.8	53.7	82.8	86.2
Гүү	258.5	371.4	421.8	39.8	62.6	65.6
Үнээ	483.4	576.6	668.1	47.2	63.9	69.2
Ингэ	35.7	39.7	44.7	39.8	43.7	46.5
Эм хонь	5385.8	6143.9	6437.8	62.1	86.6	90.4
Эм ямаа	4042.0	5730.9	5953.3	47.2	83.7	86.6

Төл бойжилт

(жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

Төлийн төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}
Бүгд	7270.4	12536.7	13327.3	71.1	97.2	98.4
Унага	217.1	359.7	410.0	84.0	96.8	97.6
Тугал	421.9	563.7	654.6	87.3	97.8	98.1
Ботго	32.9	38.6	43.6	92.1	97.4	98.1
Хурга	3891.8	5989.8	6360.8	72.1	97.3	98.7
Ишиг	2706.7	5584.8	5858.5	66.8	97.1	98.2



Зүй бусаар хорогдсон том мал
(жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	2010 ^{I-VI}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}
Бүгд	9726.6	506.1	275.6	3.3	22.1	0.8
Адуу	338.2	20.6	14.2	2.3	15.2	0.7
Үхэр	550.1	41.2	25.6	3.6	21.2	1.1
Тэмээ	12.8	1.2	0.6	0.6	4.6	0.2
Хонь	4053.4	211.8	111.1	3.1	21.0	0.7
Ямаа	4772.0	231.2	124.1	3.7	24.3	0.8

2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2012 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 373.6 мян.га талбайд тариалалт хийснээс үр тариа 305.6 мян. га-д, төмс 16.1 мян.га-д, хүнсний ногоо 7.7 мян.га-д, тэжээлийн ургамал 11.7 мян.га-д, техникийн ургамал 32.5 мян.га-д тариалсан байна.

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеийнхээс 33.2 мян.га буюу 9.8 хувиар нэмэгдсэнээс үр тарианых 6.7 мян.га буюу 2.2 хувь, төмснийх 1.2 мян.га буюу 8.3 хувь, хүнсний ногооных 81.6 га буюу 1.1 хувь, тэжээлийн ургамлынх 3.2 мян.га буюу 37.2 хувиар өссөн байна.

УРГАЦ ХУРААЛТАНД АЖИЛЛАХ ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДЛЫН МЭДЭЭ

2012.07.05

Аймгийн нэр	Комбайн		Хадагч /Жатка/		Будаа цэвэрлэгч		Үр сортлогч		Будаа ачигч		Төмсний комбайн		Даршны комбайн		Төмс сортлогч		Төмс ухагч		Механикжсан үтрэм	
	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн	дансаар	ажилд бэлэн
1 Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	2	4	4	0	0
2 Говь-Алтай	7	7	10	8	2	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	20	18	1	1
3 Завхан	3	3	1	1	2	2	0	0	1	1	0	0	0	0	0	0	12	7	0	0
4 Увс	21	12	7	5	6	4	3	3	3	2	0	0	0	0	2	2	0	0	3	2
5 Ховд	8	8	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	14	14	0	0
6 Архангай	14	8	28	12	5	3	6	6	8	6	1	1	0	0	0	0	8	7	0	0
7 Баянхонгор	0	0	11	11	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
8 Булган	120	120	71	71	48	48	21	21	32	32	5	5	0	0	1	1	9	9	10	10
9 Орхон	19	19	23	23	14	14	9	9	9	9	8	8	0	0	3	3	9	9	5	5
10 Хөвсгөл	49	20	13	10	20	14	6	3	6	3	0	0	0	0	0	0	2	1	2	2
11 Дархан-Уул	32	4	9	9	15	0	10	0	15	0	3	0	0	0	0	0	12	0	2	0
12 Дундговь	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	3	3	0	0
13 Сэлэнгэ	522	369	277	210	195	120	77	69	134	126	24	14	2	2	9	6	28	22	20	12
14 Төв	201	146	130	82	67	45	14	9	46	38	33	22	0	0	10	6	104	70	19	10
15 Дорнод	20	19	18	18	10	10	4	4	11	11	0	0	0	0	0	0	4	4	0	0
16 Сүхбаатар	1	1	1	1	1	1	0	0	1	1	0	0	0	0	0	0	3	3	0	0
17 Хэнтий	45	24	27	19	16	10	4	3	11	7	0	0	0	0	0	0	0	0	2	2
Дүн	1062	760	628	482	401	272	154	127	277	236	74	50	2	2	27	20	232	171	64	44

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний хагас жилд 1018.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 81.8 тэрбум төг буюу 8.7 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний хагас жилд 2663.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 435.7 тэрбум төг буюу 19.6 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний хагас жилд оны үнээр 2874.3 тэрбум төг болж, 1908.6 тэрбум төг буюу 66.4 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	$\frac{2012^{I-VI}}{2011^{I-VI}}$ (%)
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр	422852.4	460596.2	936961.1	1018755.7	108.7
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	104566.2	117624.3	274174.9	293379.4	107.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	66044.2	75812.5	139825.7	153209.6	109.6
Тамхи үйлдвэрлэл	2921.0	2231.8	10753.8	10527.1	97.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	13195.2	12831.3	53320.5	36895.9	69.2
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1905.9	1299.8	3549.4	2981.6	84.0
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	80.7	295.7	1338.0	2663.0	199.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	505.5	493.9	992.8	1141.8	115.0
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	456.9	767.5	1134.6	2105.1	185.5
Тавилга үйлдвэрлэл, бусад	251.7	181.0	507.5	1882.7	371.0



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2011^{I-III}</i>	<i>2012^{I-III}</i>	<i>2011^{I-VI}</i>	<i>2012^{I-VI}</i>	<i>Үүнээс: гадаадад</i>
Аж үйлдвэр, бүгд	1028745.8	1249644.5	2391296.6	2874336.9	1908584.2
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	195776.8	335552.5	522295.1	901586.7	355287.7
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	127794.0	169127.8	276820.1	345560.6	2745.0
Тамхи үйлдвэрлэл	8400.0	9325.3	20100.0	20458.3	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	20753.9	19706.4	85560.0	72497.9	45944.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2333.2	2201.4	4863.5	4291.4	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	153.4	278.8	1347.8	1425.7	274.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	1878.3	2068.0	3996.1	5176.6	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2361.5	2678.8	5104.2	7014.3	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	213.6	274.9	583.8	942.8	3.2

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	$\frac{2012^{I-VI}}{2011^{I-VI}}$ (%)
Хивс	мян.м2	194.0	236.2	401.6	429.3	106.9
Сүлжмэл эдлэл	мян.ш	149.6	133.5	326.9	325.1	99.4
Самнасан ноолуур	тн	33.6	18.9	556.7	185.6	33.3
Эсгий	мян.м	19.7	84.9	84.9	119.1	140.3
Тэмээний ноосон хөнжил	мян.м	8.4	2.2	11.7	2.6	22.2
Эсгий гутал	мян.хос	9.5	7.3	19.4	14.4	74.5
Нэхий дээл	ш	4670	2004	7795	3051	39.1
Савхин гутал, ботинк	мян.хос	1.3	3.5	2.8	6.4	229.3
Барилгын модон хаалга, цонх	м2	1561.1	919.2	3481.1	3273.9	94.0
Барилгын шалны банз	м3	108.0	341.5	148.0	817.3	552.2
Зүсмэл материал	м3	1312.7	1524.8	3041.0	2448.0	80.5
Дэвтэр	мян.ш	1378.8	1991.5	3443.8	3797.8	110.3
Ариун цэврийн цаас	мян.ш	318.6	698.7	975.6	2350.3	240.9
Бичгийн цаас	тн	72.8	38.4	116.5	78.7	67.6
Сонин	сая.х.д.х	9.0	11.7	19.1	29.9	156.5
Ном	сая.х.д.х	9.9	12.3	20.4	26.1	128.1
Шахмал түлш	тн	709.9	4129.5	770.4	4129.5	536.0
Гоо сайхны тос	мян.ш	126.7	195.2	317.6	375.3	118.2
Вакуум цонх, хаалга	м2	429.1	645.4	3317.9	2968.7	89.5
Цемент	мян.тн	65.4	15.7	170.6	187.6	110.0
Бетон зуурмаг	м3	371.5	1924.1	19507.7	7029.6	36.0



Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{I-III}	2012 ^{I-III}	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	$\frac{2012^{I-VI}}{2011^{I-VI}}$ (%)
Үхрийн мах	тн	183.5	444.7	191.1	459.1	240.2
Хонины мах	тн	233.9	409.9	233.9	415.0	177.4
Адууны мах	тн	55.1	16.8	57.3	16.8	29.3
Ямааны мах	тн	59.7	299.5	59.7	300.0	502.5
Гахайн мах	тн	6.1	4.4	9.8	10.0	102.0
Өлөн гэдэс	мян.гогцоо	232.2	336.0	393.3	532.2	135.3
Хиамны зүйл	тн	484.4	442.4	1010.3	965.1	95.5
Боловсруулсан шингэн сүү	мян.л	5601.4	6498.9	10933.0	13239.8	121.1
Тараг	мян.л	1738.1	1339.0	4372.2	4313.2	98.7
Цөцгий, цөцгийн тос	тн	252.4	406.0	449.3	827.2	184.1
Аарц, бяслаг	тн	22.2	35.2	26.9	150.6	559.9
Дээд гурил	тн	6375.3	3889.8	11625.8	4474.7	38.5
Нэгдүгээр гурил	тн	19810.1	14066.2	34619.6	25078.2	72.4
Хоёрдугаар гурил	тн	2434.9	2257.2	6074.7	7879.9	129.7
Нарийн боов	тн	2852.2	3256.5	5904.3	6529.9	110.6
Бялуу	тн	89.4	154.9	253.0	416.2	164.5
Чихэр	тн	27.4	24.6	44.0	48.1	109.3
Талх	тн	4858.1	5962.6	10286.6	12121.1	117.8
Гоймон	тн	461.3	268.8	972.9	456.1	59.3
Спирт	мян.л	1130.3	1173.1	1863.9	2038.9	109.4
Архи	мян.л	6740.4	7248.1	12871.6	12991.2	100.9
Дарс	мян.л	28.9	21.8	74.0	43.8	59.2
Шар айраг	мян.л	12403.9	15405.5	26838.3	32236.1	120.1
Цэвэр ус	мян.л	4692.7	6118.8	13005.5	16974.8	130.5
Амтат ус, ундаа	мян.л	9525.9	13474.2	31250.5	36856.1	117.9
Жүүс	мян.л	7635.4	14109.1	23499.8	30049.1	127.9



Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	$\frac{2012^{I-VI}}{2011^{I-VI}} \%$
Үхрийн хөлдүү мах	т	1838.8	-	-
Адууны мах	т	91.8	250.1	272.6
Малын дайвар бүтээгдэхүүн	т	262.3	942.3	359.4
Шеврет	сая дм ²	194.7	87.9	45.1
Шевро	сая дм ²	105.4	30.0	28.5
Адууны шир	мян.ш	129.5	77.2	59.6
Хонины самнаагүй ноос	т	4883.5	1540.2	31.5
Бохир ноолуур	т	2161.9	2332.8	107.9
Самнасан ноолуур	т	164.1	211.4	128.9
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	57.8	18.3	31.7

Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-VI}	2012 ^{I-VI}	$\frac{2012^{I-VI}}{2011^{I-VI}} \%$
Өндөг	мян.ш	32649.6	41584.7	127.4
Төмс	т	4607.4	2599.9	56.4
Сонгино, сармис	т	8043.3	5104.8	63.5
Алим, лийр	т	3788.6	1422.7	37.6
Ногоон цай	т	1322.6	1005.0	76.0
Цагаан будаа	т	5085.8	13669.3	268.8
Шар будаа	т	819.4	755.9	92.3
Гурил	мян.т	40.1	36.2	90.3
Ургамлын тос	т	2621.8	3262.8	124.4
Элсэн чихэр	т	20888.7	17956.3	86.0
Хатуу чихэр	т	2753.3	2650.4	96.3
Согтууруулах биш ундаа	мян.л	9095.3	9610.4	105.7
Согтууруулах ундаа	мян.л	9506.8	12752.9	134.1
Үүнээс: Шар айраг	мян.л	8779.8	12075.8	137.5
Янжуур	сая.ш	833.8	1047.6	125.6



4.ЦАГ АГААР

2012 оны 8 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ **

УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай оронд зуны саруудаас хамгийн дулаан нь долдугаар сар бөгөөд агаарын температурын сарын дундаж нь Өмнөговь, Дорноговийн нутаг, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр 21-26, Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Алтай, Баянхонгор, Өвөрхангайн хойд, Завханы зүүн, Баян-Өлгийн өмнөд хэсгээр 10-14, бусад нутгаар 15-20 градус дулаан байдаг. Гэвч цаг агаарын нөхцөл жил бүр харилцан адилгүй. Тухайлбал: 1996 онд баруун, төвийн нутгаар, 1999-2002, 2004-2005, 2007, 2008 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 2-5 градусаар дулаан, өдрийн үнэмлэхүй их температур Орхон-Сэлэнгийн бэлчир, говийн нутгаар 36-43, бусад нутгаар 33-38 градус хүрч халж байсан бол 1976 онд баруун ба говийн нутаг, төвийн нутгийн баруун хэсгээр, 1978 онд говь ба зүүн зүгийн нутгаар олон жилийн дунджаас нилээд хүйтэрч, шөнийн үнэмлэхүй бага температур уулархаг нутгаар 3-8 градус хүйтэн, бусад нутгаар 2 градус дулаанаас 3 градус хүйтэн байжээ. Цочир хүйтрэл сарын аль ч үед ажиглагддаг.

Энэ сард олон жилийн дунджаар Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Хөвсгөл, Архангайн зүүн хэсэг, Өвөрхангай, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 80-115, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутаг, Увс, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсгээр 10-38, бусад нутгаар 40-79 мм бороо ордог боловч 1993, 1994 онд ихэнх нутгаар, 1996-1998, 2003 онд нутгийн баруун хагаст олон жилийн дунджаас 1-3 дахин их бороо орсон бол 1999-2002, 2007 онд олон жилийн дунджаас харьцангуй бага бороо орж байжээ.


Дуу цахилгаан жил бүр 4-8, зарим жил 10-14 удаа ажиглагддаг. Салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол жил бүр 1-3, зарим жилд 5-6 удаа ажиглагддаг бөгөөд салхины хамгийн их хурд 1991 онд говийн нутгийн зүүн хэсгээр түр зуур 28-36 м/с хүрч онц хүчтэй шороон шуурга шуурсан байна.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Баруун зүгийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор 18-23, бусад нутгаар 14-19 градус дулаан буюу Говь-Алтай, Баянхонгорын ихэнх, Завханы өмнөд хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус дулаан, хөрсөн дээр 0-5 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 8-13 градус, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 13-18 градус, өдөртөө 23-28 градус, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 16-21 градус дулаан

байна. Гуравдугаар арав хоногийн эхний хагаст өдөртөө Их нууруудын хотгор, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор 32-37 градус, бусад нутгаар 24-29 градус хүрч хална. Бусад хугацаанд Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 16-21 градус, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор шөнөдөө 16-21 градус, өдөртөө 29-34 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 22-27 градус дулаан байна.



Энэ сард орох борооны нийт хэмжээ нь Увсын зүүн, Ховд, Завханы хойд, Баянхонгорын зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Говь-Алтайн зүүн өмнөд, Баянхонгорын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Харин нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 12-16 м/с, зарим үед үүнээс ч давж ширүүсч болзошгүй.

Төвийн нутаг. Энэ сарын агаарын температурын дундаж нь Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар 10-15 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх ба Өвөрхангайн ихэнх, Төв аймгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд ба сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус дулаан, хөрсөн дээр 0-2 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 8-13 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 13-18 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн эхний хагаст Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 18-23 градус, Орхон, Сэлэнгийн хөндийгөөр шөнөдөө 10-15 градус, өдөртөө 28-33 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 25-30 градус дулаан байна. Бусад хугацаанд Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 1-6 градус, өдөртөө 15-20 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 22-27 градус дулаан байна.



Энэ сард Хөвсгөлийн баруун өмнөд болон зүүн хойд, Булган, Өвөрхангайн хойд, Архангайн баруун хойд болон зүүн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим бороо орох төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Сард орох борооны зонхилох хувь нь сарын эхний ба дунд арав хоногт орох төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр түр зуур 12-16 м/с, зарим үед үүнээс ч давж ширүүсч болзошгүй.

Зүүн зүгийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь 15-20 градус дулаан буюу бүх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе ба сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 13-18 градус, бусад нутгаар шөнөдөө 7-12 градус, өдөртөө 19-24 градус дулаан байна. Хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө хөрсний гадаргад хасах 2 градус хүрч цочир хүйтрэх төлөвтэй байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 12-17 градус, өдөртөө 24-29 градус дулаан байх бөгөөд хоёрдугаар арав хоногийн эхэн болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар өдөртөө 28-33 градус хүрч халах төлөвтэй байна.

Энэ сард орох борооны нийт хэмжээ нь Дорнод, Сүхбаатарын зүүн хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Харин гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүсэх бөгөөд ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

Говийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 19-24 градус дулаан буюу Өмнөговь, Дундговийн баруун хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 3-8 градус, өдөртөө 15-20 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градс, өдөртөө 20-25 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хоногийн эхэн үе, гуравдугаар арав хоногийн дунд үеэр өдөртөө 29-34 градус хүрч халах төлөвтэй байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 25-30 градус дулаан байна.

Энэ сард орох борооны нийт хэмжээ нь ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).



Нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар бороо орно. Харин нэг дүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүсэх бөгөөд ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе ба сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар түр зуур 16-18 м/с, зарим үед үүнээс ч давж ширүүсч болзошгүй.

*** - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*